



ХЭЛТЭС, АЛБА, ГАЗРЫН 2024 ОНЫ 09 ДҮГЭЭР 09-НӨӨС 13-НЫ ӨДРҮҮДЭД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

МАЙРАМДАА - ДУУЖЬ 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр



ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аймгийн Засаг даргын ээлжит шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах.
2. Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах 70353511 утас, Цахим төв болон Тамгын газрын бичиг хэргийн ажлыг гүйцэтгэх
3. Аймгийн ИТХ-ын хурлын хуралдаанаар аймгийн далбааг шинэчлэх асуудлыг оруулах
4. Аймгийн сонгуулийн хороог удирдан зохион байгуулах
5. Аймгийн Засаг даргын шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсгүүдэд орж ажиллах





ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Эрдэнэт ҮТП төслийн хөгжлийн төлөвлөгөө, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд санал өгөх асуудлыг аймгийн ИТХ-ын зөвлөл, ИТХ-аар хэлэлцүүлэх
2. 2024 оны 9 дүгээр сарын 13,14-нд Хөвсгөл аймагт зохион байгуулагдах "Хариуцлагатай Уул Уурхай" хойд бүсийн чуулга уулзалтад Орхон аймгийн төрийн болон хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулах
3. Авто зам, замын байгууламжийн ажилд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавих
4. Нийтийн тээврийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгж байгууллагуудтай уулзалт зохион байгуулах





НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт ирүүлсэн боловсролын салбарын байгууллагуудын хүсэлтийг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэх
2. Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга зүй" сургалт зохион байгуулах
3. Нийгмийн халамжийн зөвлөлийн болон хорт хавдартай иргэдэд дэмжлэг үзүүлэх аймгийн зөвлөлийн 2024 оны 3 дугаар улирлын хурлыг хуралдуулах
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн 2024 оны 03 дугаар улирлын хурлыг хийж, гэрээт ТББ-уудын хийсэн ажлын мэдээллийг хэлэлцүүлэх
5. Олон улсын ахмадын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргах, төлөвлөгөө болон хамтран ажиллах хүсэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлэх



САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аймгийн 2024 оны тодотгосон төсвийн төслийг аймгийн ИТХ-ын зөвлөлийн хурал болон АИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх
2. Аймгийн 2024 оны тодотгосон төсвийн хуваарийг бэлтгэх
3. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хүлээлгэж өгсөн төсөл арга хэмжээний гэрээг дүгнэх хурлыг зохион байгуулах
4. Болзошгүй аваарын зардлаас санхүүжилт авсан байгууллагуудаас тайланг нэхэж авах
5. Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудаас ирүүлсэн төлбөрийн хүсэлтийн дагуу Төрийн сангийн цахим удирдлагын системд гүйлгээг хянах
6. Эрхийн бүртгэлийн сан системд баримт бичгийн тохиргоог хийх
7. Төрийн сангийн цахим удирдлагын системд цахим архив үүсгэх



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Орхон аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны 2 шүүх хурал /Нойкрафт ХХК болон иргэн Жаргалсайханы нэхэмжлэлтэй/, Захиргааны хэргийн анхан шатны шүүх хурал /Эрдэнэт Оргил ХХК-ийн нэхэмжлэлтэй/, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хурал /Хуанлу хуантун ХХК-ийн нэхэмжлэлтэй/ тус тус бэлтгэж оролцох. Мөн Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд гомдол гаргаж хүргүүлэх /Чэс ХХК/
2. 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн "Хүүхэд хамгааллын тухай хууль" /шинэчилсэн найруулга/-ын талаар сургалт, нөлөөллийн ажлыг Боловсролын газар, ЦГ, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран зохион байгуулах
3. Цагдаагийн газартай хамтран сургуулийн Дотуур байруудад хяналт шалгалт хийх
4. Аймаг, сумын сонгуулийн хороо болон хэсгийн хороонд хэлтсийн дарга мэргэжилтнүүд чиг үүргийн дагуу ажиллах.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

5. Авто замын хяналтын чиглэлээр Цагаанчулуутын 36 уртааш метр төмөр бетон гүүрний ашиглалтын байдалд төлөвлөгөөт шалгалт хийх
6. Авто замын хөрөнгө оруулалтын ажлуудад урьдчилан сэргийлэх болон төлөвлөгөөт хяналт шалгалт хийх
7. Харилцаа холбооны чиглэлээр МХС ТӨХК-нд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх
8. Эрчим хүчний чиглэлээр хийгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын мөрөөр төвлөрсөн дулаан хангамжаас алслагдсан бага хүчин чадлын зуухаар халдаг сургууль, цэцэрлэгүүдэд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх





ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

1. Аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөн, Тамгын газрын шуурхай хурал, удирдлагын шуурхайгаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг гарган шуурхай хурлуудад танилцуулах
2. Шинээр батлагдаж гарсан хууль тогтоомжийг холбогдох газруудад хүргүүлэх
3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 8 сарын хэрэгжилтийг гаргаж ЗГХХГ-т цахимаар тайлагнах





ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЛБАНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Авто замын эвдрэлийг халуун асфальтаар нөхөх ажлыг эрчимжүүлэх
2. Болзошгүй аваарын зардлаар хийгдэж буй 17, 20 дугаар сургуулийн дээвэр засварын ажлыг хүлээж авах комисс ажиллах
3. Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөнд туссан ажлуудыг эрчимжүүлэх
4. 2024 оны 09 дүгээр сарын 15-наас халаалт өгөх бэлтгэл ажлыг дуусгах





ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

- 1.Зарласан 3 тендерийг нээж, үнэлэх
- 2.Нээсэн 10 тендерийг үнэлэж дуусгах
- 3.Зураг төсөв, техникийн тодорхойлолт ирсэн ажлуудыг зарлах





СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аймгийн нийгэм, эдийн засгийн байдлын оны эхний 8 сарын статистикийн танилцуулга, инфографик мэдээллийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр тархаах
2. Аймгийн нийгэм, эдийн засгийн байдлын оны эхний 8 сарын дүнг танилцуулах хэвлэлийн бага хурлыг зохион байгуулах





АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА



2024 он